



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/244

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.1.14, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Зорилтот жил болгон зарлах тухай” 15/05 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 15/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” зорилтот жилийн хүрээнд Арвайхээр суманд байгуулах хүлэмжийн цогцолборын хашаа барих зардалд 76,000,000 (далан зургаан сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх 76,000,000 (далан зургаан сая) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0407

D:My Doc. Zahiramj. Zasag darga